



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 31

Мандалговь

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 35,500,000 (гучин таван сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад тусгасан хөрөнгийг Дундговь аймаг дахь Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоож, Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа О.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 04-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



480219063

44
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын
02 өдрийн 31 тогтоолын 1 хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС ЦАГДААГИЙН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийтдүн
1	Приус 20 автомашин	1	19,800,000	19,800,000
2	Согтуурал тандагч багаж	1	3,169,000	3,169,000
3	Согтуурал хэмжигч багаж	1	7,945,000	7,945,000
4	Таблет	1	1,760,000	1,760,000
5	Энгэрийн камер	1	1,110,000	1,110,000
6	Суурин станц	1	1,716,000	1,716,000
	Нийт дүн			35,500,000 /гучин таван сая таван зуун мянга/